



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 15/245

Мандалговь

“Гоби голден сийдс” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаарын сарын 15-ны өдрийн А/379 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн дулаарал, цаг агаарын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, хуурайшилтын эсрэг модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн боловсролыг дээшлүүлэх замаар аймгийн хэмжээнд "8 ТҮМЭН МОД" тарих ХӨДӨЛГӨӨН-ийг өрнүүлэн мод тарьж, усалж, арчлан ургуулах мэдлэг, дадлага олгох зорилгоор зохион байгуулагдаж байгаа “Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд модны суулгац нийлүүлэх ажлыг “Гоби голден сийдс” ХХК-тай гэрээ байгуулсугай.

2. Захиалсан модны нэр төрөл, тоо ширхгээр чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гоби голден сийдс” ХХК-ний захирал (А.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

3. Модны суулгац нийлүүлэх ажилд шаардагдах 15,780,000 (арван таван сая долоон зуун наяд) төгрөгийг аймгийн 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийн ажлын батлагдсан зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-д, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

4862111 8